



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар A/61

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Текко ХХК-ийн “Хаан” зочид буудлын 19/332, Мөнх Ариун Ундарга ХХК-ын “Сац” зочид буудлын 19/297, Бадман дэлгэрэх ХХК-ийн “Дэлгэрэх” зочид буудлын 19/282, Монцацраг ХХК-ийн “Сэлбэ” дэн буудлын 19/268, Тусанцаг ХХК-ийн “Тусанцаг” дэн буудлын 19/90, Гинза ХХК-ийн “Эн Жи”

• 1150500163

19/159, Баху Ундарга ХХК-ийн "Парадайс" дэн буудлын 19/111, Мөнх Ариун Ундарга ХХК-ын "Сац" жуулчны баазын 19/299 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2020 оны 07 сарын  
31-ний өдрийн A/61 дүгээр  
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СВТАЖ830 1115263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Tekko XXX	2595028	Хаан	СБД-ийн, 10-р хороо, 7-р хороолол, Их тойруу 22
2	Мөнх ариун ундарга XXX	5235359	Сац	ХУД-ийн, 20-р хороо, Шаравын гудамж, Үйлдвэр-12
3	Бадман дэлгэрэх XXX	2595435	Дэлгэрэх	БЗД-ийн, 13-р хороо, Алтан тэвш АОС-93

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2020 оны 07  
дугаар сарын 31-ний өдрийн А/61  
дүгээр тушаалын хоёрдугаар  
хавсралт

5284325 СВТ 48936 1116203502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мон цацраг ХХК	2543842	Сэлбэ	СБД-ийн, 11-р хороо, Зүүн сэлбэ 4-1Б
2	Тусанцаг ХХК	5066409	Тусанцаг	ЧД-ийн, 2-р хороо, 2-40 мянгатын 11-р байр 2 тоот
3	Гинза ХХК	2341832	Эн Жи	БЗД-ийн, 2-р хороо, Б.Доржийн гудамж 2а
4	Баху ундарга ХХК	6359817	Парадайс	БЗД-ийн, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 62

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2020 оны 07  
дугаар сарын 31-ний өдрийн А/61  
дүгээр тушаалын гуравдугаар  
хавсралт

5234325 СВТ 48936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнх Ариун Үндарга ХХК	5235359	Сац	НД-ийн, 6-р хороо, Горхи-Тэрэлжийн БЦГ, Арагант
2	Туяа-Эрдэнэ ХХК	2062046	Чингэлтэй	ЧД-ийн, 17-р хороо, Баянхайрхан гудамж 98 тоот
3	Буянт анд трэвел ХХК	2794632	Аав мод	НД-ийн, 1-р хороо, Мойлтын хүр /12607/

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР